



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД  
ОРОЛЦСОН НАМ, ЭВСЛИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН**

---

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2024 он

## АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....	2
1.1 Аудитын нэр: .....	2
1.2 Аудит хийх бүрэн эрх, үндэслэл: .....	2
1.3 Үндэслэл, зорилго: .....	2
1.4 Хамрах хүрээ: .....	2
1.5 Арга зүй: .....	2
ХОЁР. ЯВЦЫН ТАЙЛАН, МЭДЭЭ .....	3
2.1 Сонгуулийн зардлын дансны мэдээлэл .....	3
2.2 Сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайлан .....	3
ГУРАВ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН .....	3
3.1 Төрийн аудитын дээд байгууллагад ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан .....	3
3.2 Сонгуулийн зардлын санхүүжилт, гүйцэтгэл, үлдэгдэл .....	4
3.3 Сонгуулийн зардлын тайлан баталгаажуулалт, тайлагнал .....	6
ДӨРӨВ. НЭГ САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ИРГЭН, ХОЁР САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ .....	6
4.1 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн талаар .....	6
ТАВ. ДҮГНЭЛТ .....	7
ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ .....	7

### Хавсралтын жагсаалт

Хавсралт 1. Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэлд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалт

### Товчилсон үгийн жагсаалт

МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУИХСТХ	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

## НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### 1.1 Аудитын нэр:

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг баталгаажуулах аудит.

### 1.2 Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3, 58 дугаар зүйлийн 58.1-д заасны дагуу “Аудитын сэдэв батлах тухай” Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 8 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны А/24, А/44 дүгээр тушаалыг тус тус үндэслэн аудитыг гүйцэтгэсэн.

### 1.3 Үндэслэл, зорилго:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1-д “Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх ...” гэж заасны дагуу Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг хянаж нэгтгэн, дүнг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, нийтэд мэдээллээ.

### 1.4 Хамрах хүрээ:

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан, аудитын дүгнэлт, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримт, материалуудыг хамруулсан.

Тус сонгуульд нийт 19 нам, 2 эвсэл оролцсон бөгөөд төрийн аудитын дээд байгууллагад 16 нам, 2 эвсэл сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн байна.

Арилжааны банкнудаас Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5<sup>1</sup>-д заасны дагуу нам, эвслийн сонгуулийн зардлын дансны хуулгыг ирүүлсэн байна.

### 1.5 Арга зүй:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, МУЕА-ын 2024 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн А/44 дүгээр тушаалаар баталсан “Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг мөрдлөг болгож сонгуулийн зардлын тайланг хянах, нотлох баримтыг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, лавлагаа авах арга зүйг ашигласан.

<sup>1</sup> Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57.5 Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

## ХОЁР. ЯВЦЫН ТАЙЛАН, МЭДЭЭ

### 2.1 Сонгуулийн зардлын дансны мэдээлэл

Төрийн аудитын байгууллагад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.4<sup>2</sup>-д заасны дагуу сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийн мэдээллийг сонгуульд оролцсон 19 нам, 2 эвсэл бүртгүүлэхээс 13 нам, 2 эвсэл бүртгүүлж, 1 нам данс нээгээгүй талаар мэдээллийг ирүүлсэн байна. Харин 5 нам мэдээллээ бүртгүүлээгүй байна.

Сонгуулийн зардлын дансны мэдээллийг бүртгүүлээгүй намын жагсаалтыг хуулийн дагуу шалган шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.3<sup>3</sup>, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.12<sup>4</sup>-т заасны дагуу Татварын ерөнхий газарт хүргүүлээ.

#### Аудитын илрүүлэлт

Сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө төрийн аудитын дээд байгууллагад мэдэгдэж, бүртгүүлээгүй. /Эх орон нам, Бүгд найрамдах нам, Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам, Монголын социал демократ нам, Монголын либерал ардчилсан нам/.

### 2.2 Сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайлан

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.4<sup>5</sup>-д заасны дагуу 19 нам, 2 эвсэл сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайлан ирүүлэхээс 14 нам, 2 эвсэл ирүүлж, 5 нам ирүүлээгүй байна.

Сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайлан ирүүлээгүй намын жагсаалтыг хуулийн дагуу шалган шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.3, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.22<sup>6</sup>-т заасны дагуу Сангийн яаманд хүргүүлээ.

Төрийн аудитын дээд байгууллагад ирүүлсэн нам, эвслийн сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайлангийн мэдээллийг [audit.mn](http://audit.mn) сайтад 2024 оны 6 дугаар сарын 26-ны өдөр байршуулж, нийтэд ил тод мэдээлсэн.

#### Аудитын илрүүлэлт

Авсан хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс гурав хоногийн өмнө төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлээгүй /Эх орон нам, Бүгд найрамдах нам, Монголын социал демократ нам, Монголын либерал ардчилсан нам, Эх орончдын нэгдсэн нам/.

## ГУРАВ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН

### 3.1 Төрийн аудитын дээд байгууллагад ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3<sup>7</sup>-д заасны дагуу төрийн аудитын дээд байгууллагад 16 нам, 2 эвсэл сонгуулийн зардлын тайланг аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлж, 3 нам тайлангаа ирүүлээгүй байна.

Тайлан ирүүлээгүй 3 намын 1 нь сонгуулийн зардлын данс нээлгээгүй талаар мэдэгдэл төрийн аудитын дээд байгууллагад ирүүлсэн бол 2 нам нь дансны дугаар, банкны нэрийн

<sup>2</sup> 51.4. Нам, эвсэл болон нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө төрийн аудитын дээд байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.

<sup>3</sup> 58.2.3.сонгуулийн санхүүжилт, түүний зарцуулалтад гарсан зөрчлийн талаар баримт бичиг үйлдэх, бүрдүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх;

<sup>4</sup> 6.12.татварын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн ..., 17.1 дүгээр зүйлийн 21, 22, 24 дэх хэсэгт заасан зөрчил;

<sup>5</sup> 58.4. Нэр дэвшигч, нам, эвсэл авсан хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс гурав хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

<sup>6</sup> 6.22.нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн ..., 17.1 дүгээр зүйлийн 25, 27 дахь хэсэгт заасан зөрчил;

<sup>7</sup> 57.3.Нам, эвсэл санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

мэдээлэл, сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг төрийн аудитын дээд байгууллагад ирүүлээгүй байна.

Сонгуулийн зардлын тайланг ирүүлээгүй намын жагсаалтыг хуулийн дагуу шалган шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.3, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.22-т заасны дагуу Сангийн яаманд хүргүүлээ.

### **Аудитын илрүүлэлт**

Санал авах өдрөөс хойш 45 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлээгүй /Эх Орон нам, Бүгд найрамдах нам, Монголконсерватив нам/.

### **3.2 Сонгуулийн зардлын санхүүжилт, гүйцэтгэл, үлдэгдэл**

Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 16 нам, 2 эвслийн дансны эхний үлдэгдэл 4.6 сая төгрөг байна. Сонгуульд оролцсон нам, эвсэл нийт 12,898.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 14,941.0 сая төгрөгийг сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулж, харилцах дансны үлдэгдэл 3.9 сая төгрөг, төлөгдөөгүй нийт 2,191.8 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл тайлагнасан байна.

Сонгуульд оролцсон нам, эвсэлд давхардсан тоогоор 142 хуулийн этгээд 3,311.4 сая төгрөг, 841 иргэн 8,744.3 сая төгрөг, нам, эвсэл 842.8 сая төгрөг, нийт 12,898.5 сая төгрөгийн мөнгөн болон мөнгөн бус хандив өгсөн байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны 2 дугаар сарын 29-ны өдрийн А/12 дугаар тушаалаар Монгол Улсын Их Хурлын сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 6,434.5 сая төгрөгөөр тогтоосон ба сонгуульд оролцсон нам, эвслүүд тогтоосон хэмжээнд зардал гаргасан байна.

### **Санхүүжилт**

Нам, эвслийн сонгуулийн зардлын тайлангаарх нийт орлого 12,898.5 сая төгрөгийг орлогын ангиллаар харуулбал. Үүнд:

Хүснэгт 1. Сонгуулийн зардлын санхүүжилт, эх үүсвэр

/сая төгрөг/

Орлогын ангилал	Тоо	Мөнгөн	Тоо	Мөнгөн бус	Нийт	
					Тоо	Дүн
Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	-	842.8	-	-	-	842.8
Хуулийн этгээдийн хандив	141	3,309.4	1	2.0	142	3,311.4
Иргэний хандив	841	8,744.3	-	-	841	8,744.3
<b>Дүн</b>	<b>980</b>	<b>12,896.5</b>	<b>1</b>	<b>2.0</b>	<b>981</b>	<b>12,898.5</b>

### **Аудитын илрүүлэлт**

Хуулийн этгээдээс 2.0 сая төгрөгийн мөнгөн бус хандив авсан нь МУИХСТХ-ийн 55 дугаар зүйлийн 55.2-т “Мөнгөн бус хандивыг сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс дуусах хүртэл хугацаанд зөвхөн нэр дэвшигчид өгнө” гэж заасантай нийцэхгүй байна. /Монголын Социал Демократ Нам-2.0 сая төгрөг/;

Иргэнээс нэг сая ба түүнээс дээш төгрөгийн 8,703.1 сая төгрөг, хуулийн этгээдээс хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн 3,298.3 сая төгрөгийн хандив авсныг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1-т заасны дагуу нийтэд мэдээллээ.

Гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага, байгуулагдаад 1 жил болоогүй хуулийн этгээдүүдээс нийт 150.0 сая төгрөгийн хандив 3 намын хандивын дансанд орж ирснийг улсын орлогод төвлөрүүлсэн байна.

Идэвхтэй эцсийн өмчлөгчөөр гадаад орны иргэн бүртгэгдсэн 5 хуулийн этгээдээс 120.0 сая төгрөгийн хандив авсан байна.

Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн  
сонгуулийн зардлын тайлан

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчин хандив өгснийг буцаан шилжүүлээгүй зөрчлийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.3, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.12-т заасны дагуу шалган шийдвэрлүүлэхээр Татварын ерөнхий газарт хүргүүлээ.

### **Зардал**

Нам, эвсэл сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 14,941.0 сая төгрөг зарцуулснаас сонгуулийн зардалд 13,886.6 сая төгрөг, бусад зардалд 1,054.4 сая төгрөг зарцуулжээ. Үүнд:

*Хүснэгт 2. Сонгуулийн зардлын гүйцэтгэл*

*/сая төгрөг/*

<b>Зардлын ангилал</b>	<b>Мөнгөн дүн</b>
<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>14,941.0</b>
<b>2.1 Сонгуулийн зардал</b>	<b>13,886.6</b>
2.1.1 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	3,580.6
2.1.2 нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал	131.9
2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	924.1
2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	917.0
2.1.5 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	2,263.5
2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	4,669.5
2.1.7 цахим орчин ашиглах зардал	1,299.5
2.1.8 өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	100.5
<b>2.2 Бусад зардлын дүн</b>	<b>1,054.4</b>

### **Аудитын илрүүлэлт**

Сонгуулийн зардлын данснаас өөр дансанд 3.6 сая төгрөгийг шилжүүлэн зарцуулсан нь МУИХСТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.4-т "Сонгуулийн зардлын данснаас өөр дансанд сонгуулийн зардал цуглуулах, зарцуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна. /Эрх чөлөөний эвсэл-3.0 сая төгрөг, Ард түмний олонхийн засаглал нам-0.6 сая төгрөг/.

Зөрчлийн жагсаалтыг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.3, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.12-т заасны дагуу шалган шийдвэрлүүлэхээр Татварын ерөнхий газарт хүргүүлээ.

### **Өр төлбөр**

Сонгуулийн зардлын тайланд нийт 2,191.8 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл байна. /МАН-411.7 сая төгрөг, Ардчилсан нам-1,338.0 сая төгрөг, Үндэсний эвсэл-60.0 сая төгрөг, Шинэ нэгдсэн эвсэл-23.5 сая төгрөг, Иргэний хөдөлгөөний нам-328.6 сая төгрөг, ХҮН нам-30.0 сая төгрөг/.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.7-д "Энэ хуульд тусгайлан зааснаас бусад хугацаанд нам, эвсэл сонгуулийн зардлын дансаа битүүмжлүүлэх бөгөөд зөвхөн орлого оруулахыг зөвшөөрнө." гэж заасны дагуу нам, эвслүүд сонгуулийн зардлын дансаа битүүмжилсэн бөгөөд сонгуулийн зардлаар хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийг сонгуулийн зардлын данснаас өөр дансаар барагдуулахаар байгаа нь МУИХСТХ-ийн 51 дүгээр зүйлийн 51.1-д "Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл болон нэр дэвшигч тус бүр улсын хэмжээнд сонгуулийн зардлын төгрөгийн нэг данстай байна." гэж заасантай нийцэхгүй байна.

### **Аудитын илрүүлэлт**

Сонгуулийн зардлаар тайлагнасан өр төлбөрөөс 30.0 сая төгрөгийг харилцагч байгууллага, хувь хүнтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь НББТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч,

худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна. /Ардчилсан нам-1.5 сая төгрөг, Шинэ нэгдсэн эвсэл-23.5 сая төгрөг, Иргэний хөдөлгөөний нам-5.0 сая төгрөг/.

### **Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив**

Хандив өгч байгаа иргэний нэр, иргэний бүртгэлийн дугаар, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгаагүй 1,700.2 сая төгрөгийн хандивыг хандивлагч нарт буцаан шилжүүлсэн байна.

### **Аудитын илрүүлэлт**

Хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй 1.0 сая төгрөгийн орлогыг зарцуулсан нь МУИХСТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.4-т "Хандив өгч байгаа иргэний нэр, иргэний бүртгэлийн дугаар, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна. /Иргэний хөдөлгөөний нам-0.7 сая төгрөг, Монголын хүний төлөө нам-0.3 сая төгрөг/.

Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг зарцуулсан зөрчлийг шалган шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.3, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.12-т заасны дагуу Татварын ерөнхий газарт хүргүүлээ.

### **3.3 Сонгуулийн зардлын тайлан баталгаажуулалт, тайлагнал**

Төрийн аудитын дээд байгууллагад 17 аудитын хуулийн этгээд МУЕА-ын 2024 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн А/44 дүгээр тушаалаар баталсан “Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын дагуу сонгуулийн зардлын тайланг баталгаажуулан ирүүлсэн байна.

Арилжааны банкнуудаас нам, эвслийн сонгуулийн зардлын дансны хуулгыг ирүүлсэн боловч ирүүлсэн дансны хуулга нь харьцсан дансны мэдээлэлгүй байгаа нь дүгнэлт өгөхөд хүндрэл бий болгосон.

## **ДӨРӨВ. НЭГ САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ИРГЭН, ХОЁР САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ**

### **4.1 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн талаар**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1<sup>8</sup>-д заасны дагуу төрийн аудитын дээд байгууллагаас нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээллийг нэгтгэлээ.

Үүнд, давхардсан тоогоор 509 иргэн 8,703.1 сая төгрөгийн нэг сая ба түүнээс дээш төгрөгийн мөнгөн хандив, 126 хуулийн этгээд 3,298.3 сая төгрөгийн хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн мөнгөн хандивыг нам, эвсэлд өгсөн байна.

Төрийн аудитын дээд байгууллагаас иргэн, хуулийн этгээдээс өгсөн дээрх мөнгөн хандивын мэдээллийг [audit.mn](http://audit.mn) сайтад байршуулж, нийтэд ил тод мэдээллээ.

<sup>8</sup> 58.1.Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

## **ТАВ. ДҮГНЭЛТ**

Сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг аудитын хуулийн этгээдүүд баталгаажуулан, үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн гэж дүгнэлт гарган Үндэсний аудитын газарт ирүүлсэн боловч аудитаар хянахад хуульд нийцээгүй зөрчлийг илрүүлэхгүй байгаа тул хариуцлагын талаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт зохицуулалт оруулах шаардлагатай байна.

Сонгуульд оролцсон намууд нь тайлан, мэдээг хуульд заасан хугацаанд бүрэн ирүүлээгүй нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.4, 57 дугаар зүйлийн 57.3, 58 дугаар зүйлийн 58.4-т заасантай нийцэхгүй байна.

Төрийн аудитын байгууллага давхардсан тоогоор 509 иргэнээс нэг сая ба түүнээс дээш төгрөгийн 8,703.1 сая төгрөг, 126 хуулийн этгээдээс хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн 3,298.3 сая төгрөгийн хандив авсныг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1-т заасны дагуу нийтэд мэдээлсэн.

Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 16 нам, 2 эвслийн дансны эхний үлдэгдэл 4.6 сая төгрөг байна. Сонгуульд оролцсон нам, эвсэл нийт 12,898.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 14,941.0 сая төгрөгийг сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулж, харилцах дансны үлдэгдэл 3.9 сая төгрөг, төлөгдөөгүй нийт 2,191.8 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл тайлагнасан байна.

Сонгуулийн зардлын тайлангаар 2,191.8 сая төгрөгийг өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч, хуулийн этгээд, иргэнд төлөхөөр тайлагнасан нь хуулийн этгээд, иргэний авлага барагдахгүй байх эрсдэлтэй бөгөөд барагдуулах эх үүсвэрийг тодорхой мэдээлж, тайлагнах зохицуулалт шаардлагатай байна.

## **ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ**

### ***Сонгуулийн Ерөнхий Хороонд:***

Сонгуулийн зарим тодорхой бус харилцааг сонгуульд оролцогчдын эрх, ашигт нийцүүлэн ойлгомжтой байдлаар зохицуулж, шийдвэрлэх шаардлагатай байна. Үүнд:

- Сонгуулийн зардлын данс нээхгүй байх нөхцөл, шаардлага, үүнтэй холбоотойгоор хэрхэн тайлагнаж хяналт хийлгэх, мэдээлэх зохицуулалт;
- Данс нээлгэсэн ч орлого бүрдээгүй, зарлага гараагүй сонгуулийн зардлын тайланг хэрхэн тайлагнах, хяналт хийлгэх, мэдээлэх зохицуулалт;
- Сонгуулийн зардлын тайланд өглөг үүсгэх нөхцөл, шаардлага, цаашид үүссэн өглөгийг барагдуулах эх үүсвэрийг хэрхэн тайлагнах, мэдээлэх зохицуулалт;
- Арилжааны банкнаас дансны хуулгыг Үндэсний аудитын газарт ирүүлэхдээ мэдээллийг харьцсан дансаар иж бүрэн бэлтгэж, боловсруулалт хийх боломжтой файл хэлбэрээр хүргүүлж байх талаар зохицуулалт хийж, арга хэмжээг авах.

**Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуульд ороцсон нам, эвсэлд  
Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн  
этгээдийн жагсаалт**

/төгрөгөөр/

№	Нам, Эвслийн нэр	Хандив өгсөн иргэн болон хуулийн этгээдийн нэр	Мөнгөн хандивын дүн	
			Иргэн /Нэг сая төгрөгөөс дээш/	Хуулийн этгээд /Хоёр сая төгрөгөөс дээш/
1	Монгол Ардын нам	Д.Энхбат	10,000,000.00	
2	Монгол Ардын нам	Г.Батцэнгэл	10,000,000.00	
3	Монгол Ардын нам	Д.Үүрцайх	10,000,000.00	
4	Монгол Ардын нам	Д.Энхжаргал	10,000,000.00	
5	Монгол Ардын нам	Пүрэвжав	10,000,000.00	
6	Монгол Ардын нам	Оргил	10,000,000.00	
7	Монгол Ардын нам	Батдэлгэр	10,000,000.00	
8	Монгол Ардын нам	Энхтуул	10,000,000.00	
9	Монгол Ардын нам	Тамир	10,000,000.00	
10	Монгол Ардын нам	Батжаргал	10,000,000.00	
11	Монгол Ардын нам	Төгс-Эрдэнэ	10,000,000.00	
12	Монгол Ардын нам	Эрдэнэтуул	10,000,000.00	
13	Монгол Ардын нам	Гончигсумлаа	10,000,000.00	
14	Монгол Ардын нам	Батчимэг	10,000,000.00	
15	Монгол Ардын нам	Тунгалаг	10,000,000.00	
16	Монгол Ардын нам	Болормаа	10,000,000.00	
17	Монгол Ардын нам	Баяраа	10,000,000.00	
18	Монгол Ардын нам	Баттулга	10,000,000.00	
19	Монгол Ардын нам	Ганбаяр	10,000,000.00	
20	Монгол Ардын нам	Сувдаа	10,000,000.00	
21	Монгол Ардын нам	Сумъяабазар	10,000,000.00	
22	Монгол Ардын нам	Батбаясгалан	10,000,000.00	
23	Монгол Ардын нам	Батзул	10,000,000.00	
24	Монгол Ардын нам	Дагва	10,000,000.00	
25	Монгол Ардын нам	Төгөлдөр	10,000,000.00	
26	Монгол Ардын нам	Сэргэлэнбаатар	10,000,000.00	
27	Монгол Ардын нам	Оюунгэрэл	10,000,000.00	
28	Монгол Ардын нам	Одсүрэн	10,000,000.00	
29	Монгол Ардын нам	Болорсайхан	10,000,000.00	
30	Монгол Ардын нам	Батзориг	10,000,000.00	
31	Монгол Ардын нам	Ууганзаяа	10,000,000.00	
32	Монгол Ардын нам	Мөнхбат	10,000,000.00	
33	Монгол Ардын нам	Сумъяабаатар	10,000,000.00	
34	Монгол Ардын нам	Сэмжидмаа	10,000,000.00	
35	Монгол Ардын нам	Бямбасайхан	10,000,000.00	
36	Монгол Ардын нам	Мөнхбаатар	10,000,000.00	
37	Монгол Ардын нам	Гангамөрөн	10,000,000.00	
38	Монгол Ардын нам	Хэрлэн	10,000,000.00	
39	Монгол Ардын нам	Ихбаяр	10,000,000.00	
40	Монгол Ардын нам	Жавзандорж	10,000,000.00	
41	Монгол Ардын нам	Ганцэцэг	10,000,000.00	
42	Монгол Ардын нам	Энхжаргал	10,000,000.00	
43	Монгол Ардын нам	Ган-Эрдэнэ	10,000,000.00	
44	Монгол Ардын нам	Саранчимэг	10,000,000.00	
45	Монгол Ардын нам	Бат-Амгалан	10,000,000.00	
46	Монгол Ардын нам	Булгантуяа	10,000,000.00	
47	Монгол Ардын нам	Чинбүрэн	10,000,000.00	
48	Монгол Ардын нам	Баярмөнх	10,000,000.00	
49	Монгол Ардын нам	Ууганбаяр	10,000,000.00	
50	Монгол Ардын нам	Сүхбаатар	10,000,000.00	
51	Монгол Ардын нам	Пүрэвдагва	10,000,000.00	
52	Монгол Ардын нам	Оюунзул	10,000,000.00	
53	Монгол Ардын нам	Энхбаяр	10,000,000.00	

54	Монгол Ардын нам	Гүрсоронзон	10,000,000.00	
55	Монгол Ардын нам	Ариунжаргал	10,000,000.00	
56	Монгол Ардын нам	Цэлмүүн	10,000,000.00	
57	Монгол Ардын нам	Эрдэнэжаргал	10,000,000.00	
58	Монгол Ардын нам	Золзаяа	10,000,000.00	
59	Монгол Ардын нам	Цогтбаатар	10,000,000.00	
60	Монгол Ардын нам	Мөнх-Оргил	10,000,000.00	
61	Монгол Ардын нам	Мөнхцэцэг	10,000,000.00	
62	Монгол Ардын нам	Төрболд	10,000,000.00	
63	Монгол Ардын нам	Мөнгөншагай	10,000,000.00	
64	Монгол Ардын нам	Төмөрбаатар	10,000,000.00	
65	Монгол Ардын нам	Шагдарсүрэн	10,000,000.00	
66	Монгол Ардын нам	Цэнгэл	10,000,000.00	
67	Монгол Ардын нам	Нямбаатар	10,000,000.00	
68	Монгол Ардын нам	Учрал	10,000,000.00	
69	Монгол Ардын нам	Жаргалмаа	10,000,000.00	
70	Монгол Ардын нам	Анужин	10,000,000.00	
71	Монгол Ардын нам	Батшугар	10,000,000.00	
72	Монгол Ардын нам	Алтаншагай	10,000,000.00	
73	Монгол Ардын нам	Хуягбаатар	10,000,000.00	
74	Монгол Ардын нам	Цэнд-Аюуш	10,000,000.00	
75	Монгол Ардын нам	Сандагсүрэн	10,000,000.00	
76	Монгол Ардын нам	Баттөр	10,000,000.00	
77	Монгол Ардын нам	Ундармаа	10,000,000.00	
78	Монгол Ардын нам	Мөнхцэцэг	10,000,000.00	
79	Монгол Ардын нам	Мөнхчулуун	10,000,000.00	
80	Монгол Ардын нам	Говьсайхан	10,000,000.00	
81	Монгол Ардын нам	Мандухай	10,000,000.00	
82	Монгол Ардын нам	Батбаяр	10,000,000.00	
83	Монгол Ардын нам	Оюунчимэг	10,000,000.00	
84	Монгол Ардын нам	Сүхбаатар	10,000,000.00	
85	Монгол Ардын нам	Батсүмбэрэл	10,000,000.00	
86	Монгол Ардын нам	Мөнхбат	10,000,000.00	
87	Монгол Ардын нам	Ариунтуяа	10,000,000.00	
88	Монгол Ардын нам	Хишигсүрэн	10,000,000.00	
89	Монгол Ардын нам	Батхишиг	10,000,000.00	
90	Монгол Ардын нам	Наранцэцэг	10,000,000.00	
91	Монгол Ардын нам	Сарангэрэл	10,000,000.00	
92	Монгол Ардын нам	Амартүвшин	10,000,000.00	
93	Монгол Ардын нам	Алдаржавхлан	10,000,000.00	
94	Монгол Ардын нам	Цэрэн	10,000,000.00	
95	Монгол Ардын нам	Батсайхан	10,000,000.00	
96	Монгол Ардын нам	Номин	10,000,000.00	
97	Монгол Ардын нам	Оргил	10,000,000.00	
98	Монгол Ардын нам	Мөнхтамир	10,000,000.00	
99	Монгол Ардын нам	Мягмар	10,000,000.00	
100	Монгол Ардын нам	Өнөбат	10,000,000.00	
101	Монгол Ардын нам	Эрдэнэбаяр	10,000,000.00	
102	Монгол Ардын нам	Мөнхгэрэл	10,000,000.00	
103	Монгол Ардын нам	Батнасан	10,000,000.00	
104	Монгол Ардын нам	Нямжав	10,000,000.00	
105	Монгол Ардын нам	Сандаг-Очир	10,000,000.00	
106	Монгол Ардын нам	Даваасүрэн	10,000,000.00	
107	Монгол Ардын нам	Отгонболд	10,000,000.00	
108	Монгол Ардын нам	Номинчулуун	10,000,000.00	
109	Монгол Ардын нам	Амарсайхан	10,000,000.00	
110	Монгол Ардын нам	Раднаабазар	10,000,000.00	
111	Монгол Ардын нам	Нарантуяа	10,000,000.00	
112	Монгол Ардын нам	Отгонсүрэн	10,000,000.00	
113	Монгол Ардын нам	Баттөмөр	10,000,000.00	
114	Монгол Ардын нам	Г.Тэмүүлэн	10,000,000.00	
115	Монгол Ардын нам	Б.Цэрэннадмид	10,000,000.00	
116	Монгол Ардын нам	Д.Мөнхбат	10,000,000.00	
117	Монгол Ардын нам	С.Төмөр-Очир	10,000,000.00	

118	Монгол Ардын нам	Ц.Мөнхнасан	10,000,000.00	
119	Монгол Ардын нам	Б.Өсөхбаяр	10,000,000.00	
120	Монгол Ардын нам	Л.Эрхбаатар	10,000,000.00	
121	Монгол Ардын нам	Т.Ганболд	10,000,000.00	
122	Монгол Ардын нам	Б.Лхагвадорж	10,000,000.00	
123	Монгол Ардын нам	Н.Мандуул	10,000,000.00	
124	Монгол Ардын нам	Ө.Золбаяр	10,000,000.00	
125	Монгол Ардын нам	С.Нэргүй	10,000,000.00	
126	Монгол Ардын нам	Б.Ганцэцэг	10,000,000.00	
127	Монгол Ардын нам	Т.Цолмон	10,000,000.00	
128	Монгол Ардын нам	Б.Амгалан	10,000,000.00	
129	Монгол Ардын нам	Х.Баделхан	10,000,000.00	
130	Монгол Ардын нам	Т.Аубакир	10,000,000.00	
131	Монгол Ардын нам	Д.Бауыржан	10,000,000.00	
132	Монгол Ардын нам	Н.Бейбитхан	10,000,000.00	
133	Монгол Ардын нам	Х.Арман	10,000,000.00	
134	Монгол Ардын нам	С.Хонаев	10,000,000.00	
135	Монгол Ардын нам	Х.Нурлат	10,000,000.00	
136	Монгол Ардын нам	К.Айдос	10,000,000.00	
137	Монгол Ардын нам	С.Асылбек	10,000,000.00	
138	Монгол Ардын нам	Ж.Тамир	10,000,000.00	
139	Монгол Ардын нам	О.Хулан	10,000,000.00	
140	Монгол Ардын нам	Х.Манчук	10,000,000.00	
141	Монгол Ардын нам	А.Ариунболд	10,000,000.00	
142	Монгол Ардын нам	З.Батырбек	10,000,000.00	
143	Монгол Ардын нам	Т.Нурамгүл	10,000,000.00	
144	Монгол Ардын нам	Ц.Чингарьд	10,000,000.00	
145	Монгол Ардын нам	Н.Бямбагэрэл	10,000,000.00	
146	Монгол Ардын нам	Б.Батцэцэг	10,000,000.00	
147	Монгол Ардын нам	М.Баярмагнай	10,000,000.00	
148	Монгол Ардын нам	С.Баярмөнх	10,000,000.00	
149	Монгол Ардын нам	Б.Батбаяр	10,000,000.00	
150	Монгол Ардын нам	Б.Даваадалай	10,000,000.00	
151	Монгол Ардын нам	Б.Энхтүвшин	10,000,000.00	
152	Монгол Ардын нам	М.Билэгт	10,000,000.00	
153	Монгол Ардын нам	Ж.Бат-Эрдэнэ	10,000,000.00	
154	Монгол Ардын нам	Б.Бат-Эрдэнэ	10,000,000.00	
155	Монгол Ардын нам	М.Ариунболд	10,000,000.00	
156	Монгол Ардын нам	Ц.Батбаяр	10,000,000.00	
157	Монгол Ардын нам	Б.Баярмагнай	10,000,000.00	
158	Монгол Ардын нам	Ё.Отгонбаяр	10,000,000.00	
159	Монгол Ардын нам	Б.Хажидмаа	10,000,000.00	
160	Монгол Ардын нам	Ш.Насандулам	10,000,000.00	
161	Монгол Ардын нам	Мөнхмарал	10,000,000.00	
162	Монгол Ардын нам	Ц.Гарамжав	10,000,000.00	
163	Монгол Ардын нам	В.Сүррагчаа	10,000,000.00	
164	Монгол Ардын нам	Чулуунзагд	10,000,000.00	
165	Монгол Ардын нам	Отгонбаяр	10,000,000.00	
166	Монгол Ардын нам	Хишигжаргал	10,000,000.00	
167	Монгол Ардын нам	Бат-Эрдэнэ	10,000,000.00	
168	Монгол Ардын нам	Баянмөнх	10,000,000.00	
169	Монгол Ардын нам	Чинзориг	10,000,000.00	
